

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: **50-70 тн даацтай
карьерийн автосамосвал /HOWO-5707 маркийн
автосамосвалтай дүйцэхүйц/ нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202112148

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос **50-70 тн даацтай карьерийн автосамосвал /HOWO-5707 маркийн автосамосвалтай дүйцэхүйц/** нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 100 хувиас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100 хувиас багагүй байна.

Тендерийн хамт 12,160,000 төгрөгийн дүн бүхий тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 11 цаг 00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 11:10 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрнө.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 505 тоот өрөө, утас: 450060 + 180

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ